


Монгол хэл 5-р анги “Байгаль эх дэлхийгээ хайрлая”


Даш хүү нэгэн өдөр “Өвөө үүнийг хар даа” гэсээр хувинд хийсэн жараахайнуудаа үзүүлэв. Тэгээд өвөөдөө “Голын эрэг дээр барилгын ажил явагдаж байна. Тэнд байгаа тогтоол усанд зөндөө их жараахай байна. Өвөө, өнөөдөр орой энэ жараахайнуудаар хоёулаа сайхан хоол хийх үү?” гэв. Өвөө нь “Чи тэгээд бүгдийг нь идэх юм уу?” гэлээ. Даш “Бүгдийг нь ч арай барахгүй л дээ, үлдсэнийг нь хаячихгүй юу? гэхэд өвөө нь “Идэхгүй байж, энэ олон жараахайг барьж яах гэв? Ямар задарсан тархи вэ чи?” гэж дуугаа өндөрсгөн түүнийг зэмлэв.



Удалгүй өвөө нь “Наадуулаа хаанаас барив? Өвөөдөө заагаад аль” гэж Дашид хэллээ. Даш өвөөгөө дагуулан тогтоол усан дээр ирэв. Голын эргээр далан барих барилгын ажил эхлээд ид бужигнаж байлаа. Голын усыг хааснаас болж, тогтоол үүссэн ба дотор нь өч төчнөөн загас харагдана. Хүмүүс лусын амьтныг ингэж хамаагүй зовоож болохгүй юмсан гэж хэлэн харж зогстол:

Даш


- Зөндөө байгаа биз дээ, өвөө.
- Тийм байна. Гэхдээ энэ чигт нь орхиж болохгүй дээ. Удахгүй ус нь багасахаар загаснууд үхчихнэ гэж өвөө санаа зовсон янзтай хэлэв. Тэгээд “Миний хүү, гэрээсээ загасны тороо аваад ир!” гээд өвөө нь ханцуйгаа шамлан оров.
- Өвөө тэгээд яах гэж байгаа юм?
- Яах юу байдаг юм. Голд нь буцааж хийе.
- Гэхдээ энэ чинь олон загас байна шүү дээ! Нэг өдөр амжихгүй ээ! Тэртээ тэргүй удахгүй үхэх юм чинь орхичхооч! гэж Дашийг хэлтэл, өвөөгийн дуудахин өндөрсөж:
- Тэгвэл чамайг нэг өдөр юм идэхгүй бай гээд хаяад явчихвал чи яах вэ? Гэхэд
- Гэхдээ би загас биш юм чинь!
- Загас ч бай, хүн ч бай адилхан амьтай.
- Тэр ч тийм л дээ.
- Идэхийн тулд барих, харсаар байж үхүүлэх хоёр чинь өөр гэж өвөө учирлан хэллээ.




Даш дуртай дургүй торонд гүйлээ. Тэр хоёр өдөржингөө загас шүүрдэн гол руу буцаан хийв. Загас маш их байсан болохоор дуусах шинж алга. Жирийн үед нуруу өвдөөд гээд суучихдаг өвөөд нь загас шүүрдэн тонголзох нь их л хэцүү байгаа бололтой. Гэвч өвөө нь дуу шуугүй хийсээр л байлаа. Даш өвөөдөө тусалж загасыг зөөлцөв.

Бид идэхийн тулд загас барьдаг. Идэхгүй байж загас барих туйлын буруу зүйл гэж өвөө нь ярилаа. Даш өвөөдөө туслах тусам “Загас юм чинь үхсэн ч яахав!” гэж бодож байсан бодол нь алга болов. Нэг мэдэхэд загаснуудад хандан,

- Алив зугтаарай. Хурдал, хурдал гэж байлаа. Хоёр хоногийн дараа тогтоол усанд загас үзэгдэхээ болив. Бүгд эсэн мэнд голын усанд оржээ. Загасыг олноор нь барьж болохгүй. Түүнийг хамгаалж, үржүүлэх хэрэгтэй. Тэгж байж л байгаль баян, бид хоолтой байна гэсэн өвөөгийн сургаал үнэн байлаа. Байгаль дэлхийгээ хайрлая.





1. **“тогтоол усанд”** - гэсэн үгийн утгад тохирох хэсгийг сонгоно уу.

A. далайн их ус

B. урсгал голын ус

C. хэсэг газар тогтсон урсгал ус

D. хэсэг газар тогтсон тогтонги ус

2. **"задарсан тархи"** гэсэн хэлц үгийн утгад тохирох хэсгийг сонгоно уу.

A. будлиу хүүхэд

B. дуулгавартай хүүхэд

C. сониучхан хүүхэд

D. үг авдаггүй дураараа хүүхэд



3. Цаг хугацаа заасан утгаар дэлгэрүүлсэн өгүүлбэрийг олоорой.


- A. Бүгд эсэн мэнд голын усанд оржээ.
- B. Идэхгүй байж загас олноор барих туйлын буруу.
- C. Тэнд байгаа тогтоол усанд зөндөө олон жижиг жараахай бий.
- D. Хоёр хоногийн дараа тогтоол усанд загас үзэгдэхээ болив.

4. "Голын усыг хаасан тогтоол үүссэн " гэсэн өгүүлбэрийн цэгийн оронд тохирох утгатай холбох үгийг сонгоно уу.

5. Даш хүүгийн хийсэн үйлийн зөв дараалуулсан хэсгийг олоорой.

1. Жараахайг аврахаар гол руу зөөсөн.
2. Жараахай байгаа газрыг өвөөдөө зааж өгсөн.
3. Өвөөгийн сургаал үнэн болохыг ойлгосон.
4. Хувинтай жараахайнуудыг гэртээ авчирсан

A. 1, 3, 2, 4 B. 3, 2, 4, 1 C. 4, 2, 1, 3 D. 1, 2, 3, 4



6. Даш “Загаснуудыг тэр чигт нь орхичхож болохгүй юм уу?” гэж хэлсний учир нь юу вэ?

A. олон жараахайг голд буцаах хэцүү санагдсан учир

B. өвөө сургаалаа хайрласан учир

C. тогтоол уснаас голын усруу зөөх боломжгүй учир

D. удахгүй голын усандаа орчих байсан учир

7. Эхийн гол санаа юу байсан бэ?

A. Ан амьтан, байгалиа хайрлаж хамгаалах тухай

B. Голын орчинд барилгын ажил явуулж болохгүй тухай

C. Загасыг хэрхэн яаж үржүүлэх тухай

D. өвөө хүү хоёрын тухай.



8. Эхийн утгад тохирох зүйр үгийг сонгоод өгүүлбэр зохион бичээрэй.

А. Уулыг өндөр гэж бүү няц, явбал давна. Ажлыг их гэж бүү шантар, хийвэл дуусна.

В. Дэм дэмэндээ дээс эрчиндээ
Өгүүлбэр:.....
.....

9. Яагаад? Ямар учраас гэсэн асуух үгийг ашиглан загаснууд тогтоол усанд орсон шалтгааныг илрүүлэх 1 асуулт зохиож бичээрэй.

.....
.....

10. Өвөөгийн хүүдээ хандан хэлсэн сургамжаас 3-ыг тоочин бичнэ үү?

1.....

2.

3.....